Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын 2022 оны санхүүгийн тайлан дахь Тайлант онд баталсан татварын болон татварын бус орлогыг мөнгөн сууриар хөтөлж, ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 тоот захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон сумын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 769,574.57 мянган төгрөгөөр буюу 21.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
МӨНГӨН ХӨРӨНГӨ	449,298.31	469,399.55	20,101.25
АВЛАГА	399,642.12	345,561.21	-54,080.92
БАРАА МАТЕРИАЛ	225,075.43	34,844.13	-190,231.29
Түүхий эд материал	81,124.11	15,733.88	-65,390.22
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,484,887.23	1,813,138.29	-671,748.95
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,558,903.10	2,789,765.66	-769,137.44
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	848.55	285.69	-562.87
Засгийн газрын хувь оролцоо	3,558,054.54	2,789,479.97	-768,574.57
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,558,903.10	2,789,765.66	-769,137.44

Эх сурвалж: Орхон сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Нийт хөрөнгө өмнөх оноос 21.6 хувиар буурсан нь Засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллага”-ын төсвийг БЕГ-ын даргад шилжүүлж системийн бодлогын өөрчлөлт орсонтой холбоотойгоор буурчээ.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,408,198.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 60,303.74 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банкинд байгаа бэлэн мөнгө	449,298.31	469,399.55	20,101.25
Төгрөг	449,298.31	469,399.55	20,101.25
Төрийн сангийн харилцах	443,946.32	469,399.55	25,453.24
Нэмэлт санхүүжилтийн харилцах	5,351.99	-	(5,351.99)
Гадаад валют	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Дүн	1,347,894.93	1,408,198.66	60,303.74

Эх сурвалж: Сайхан сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа ОНЕО-ын дансанд 114,030.9, ОНХС-д 278,935.5, Сум хөгжүүлэхийн дансанд 34,711.0, Байгаль хамгаалах сангийн дансанд 22,396.6, ЖДҮД сангийн дансанд 19,325.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 324,231.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 72,814.6 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
АВЛАГА	399,642.12	345,561.21	54,080.92
Ажиллагчидтай холбогдсон авлага	488.33	518.07	(29.74)
Төлбөртэй үйлчилгээний авлага	126,609.00	-	126,609.00
Бусад авлага	272,544.79	345,043.14	(72,498.34)
Байгууллагаас авах авлага	2,128.33	1,812.00	316.33
Хувь хүмүүсээс авах авлага	270,416.46	343,231.14	(72,814.67)

Эх сурвалж: Орхон сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Авлагын үлдэгдэлд 5-с дээш жилийн насжилттай 343,231.14 мянган төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

Зээлийн хүүгийн авлагаар Сум хөгжүүлэх санд 252,618.5, ЖДҮДС-д 78,370.5, байгаль хамгаалах санд 1,832.0, малжуулах төсөлд 12,222.2, ИТХ-д 518.0 мянган төгрөгийн авлагын үүссэн нийт 11,394.5 мянган төгрөгийн авлага тус тус байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 0.0 сая төгрөг байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0	0	0
Урьдчилгаа тооцоо	0	0	0
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0	0	0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0	0	0
Дүн	0	0	0

Эх сурвалж: Орхон сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 46.5 сая төгрөг болж, өмнөх оноос 243.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	81,124.11	15,733.88	(65,390.22)
Тусгай зориулалттай материал	19,707.16	15,733.88	(3,973.28)
Эм боох материал	61,416.94	-	(61,416.94)
Хангамжийн материал	143,951.32	19,110.25	(124,841.07)
Бичиг хэргийн материал	787.86	-	(787.86)
Аж ахуйн материал	1,753.75	-	(1,753.75)
Түлш, шатах тослох материал	3,446.00	3,274.00	(172.00)
Барилгын засварын материал	390.00	-	(390.00)
Хүнсний материал	7,840.37	-	(7,840.37)
Бусад хангамжийн материал	129,733.34	15,836.25	(113,897.09)
Нийт дүн	450,150.86	69,688.27	(380,462.59)

Эх сурвалж: Орхон сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Тайлант онд ЗДТГ 52,828.8, ИТХ 4,451.0, байгаль хамгаалах сан 2,684.9 мянган төгрөгөөр буюу нийт 59,964.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол ЗДТГ 49,060.6, ИТХ 4,451.0,

байгаль хамгаалах сан 6,145.0, Засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийг БЕГ-ын даргад шилжүүлсэн буюу бодлогын өөрчлөлттэй холбоотойгоор боловсролын салбар 89,695.8, ЭМТ 100,843.5 мянган төгрөгөөр тус тус бараа материал буурчээ.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 126,822.4 төгрөг болж, өмнөх оноос өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	0	126,822.4	126,822.4
Дүн	0	126,822.4	126,822.4

Эх сурвалж: Орхон сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,626,276.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,343,497.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,362,388.90	1,573,900.69	(788,488.22)
Барилга, байгууламж, орон сууц	2,307,562.08	1,547,958.31	(759,603.77)
Хуримтлагдсан элэгдэл	(640,524.21)	(353,538.27)	286,985.94
Авто-тээврийн хэрэгсэл	257,034.69	273,099.69	16,065.00
Хуримтлагдсан элэгдэл	(179,835.52)	(165,203.23)	14,632.28
Машин тоног төхөөрөмж(компьютер)	362,044.69	181,442.24	(180,602.45)
Хуримтлагдсан элэгдэл	(141,555.50)	(55,454.35)	86,101.15
Тавилга, аж ахуйн эд хогшил	181,550.83	64,285.06	(117,265.77)
Хуримтлагдсан элэгдэл	(79,345.13)	(38,448.48)	40,896.66
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,921.96	1,921.96	-
Бусад үндсэн хөрөнгө	142,714.41	164,869.58	22,155.17
Хуримтлагдсан элэгдэл	(53,039.74)	(47,031.83)	6,007.91
Дуусаагүй барилга, байгууламж	174,503.58	-	(174,503.58)
Ном	29,356.76	-	(29,356.76)
Биет бус хөрөнгө	122,498.33	239,237.60	116,739.27
Програм хангамж	6,845.00	1,745.00	(5,100.00)
Хуримтлагдсан элэгдэл	(4,056.67)	(1,745.00)	2,311.67
Бусад биет бус хөрөнгө	119,710.00	239,237.60	119,527.60
Дүн	4,969,774.47	3,626,276.57	(1,343,497.90)

Эх сурвалж: Орхон сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

ЗДТГ-т 536,200.5, ИТХ-д 5,414.9 мянган төгрөгөөр тус үндсэн хөрөнгө нэмэгдсэн бол холбогдох дээд байгууллагын шийдвэрээр ЗДТГ 14,800.0 мянган төгрөгийн авто машин дуудлага худалдаагаар худалдсан, 174,503.5 мянган төгрөгийн дуусаагүй авто замыг данс хооронд шилжүүлсэн, ИТХ 16,634.0 Засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийг БЕГ-ын даргад шилжүүлсэн буюу бодлогын

өөрчлөлттэй холбоотойгоор боловсролын салбар 1,020,433.2, соёлын салбар 165,658.4, ЭМТ 274,904.8 мянган төгрөгөөр тус тус үндсэн хөрөнгө буурчээ.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн 30 тооны 3,249.9 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь УСНББОУС-17, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т "Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ" гэж заасантай, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй./ЗДТГ/

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 285.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,199.85 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	8,485.53	285.69	-8,199.85
Ажилчидтай холбогдсон өглөг	923.98	135.69	-788.30
Бусад өглөг	7,561.55	150.00	-7,411.55
Байгууллагад төлөх өглөг	7,561.55	0.00	-7,561.55
Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	150.00	150.00

Эх сурвалж: Орхон сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 285.6 мянган төгрөг байна. Үүнээс ЗДТГ-ын хувь хүнд өгөх өглөг 150.0, ажилчидтай холбоотой өглөг 135.7 мянган төгрөг байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,980.7 сая төгрөг болж, өмнөх оноос 4,230.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	864,346.44	490,242.69	-374,103.75
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	490,242.69	490,242.69
Хуримтлагдсан үр дүн	1,484,567.78	1,779,738.74	295,170.96
Өмнөх үеийн үр дүн	1,264,951.00	2,574,532.17	1,309,581.17
Тайлант үеийн үр дүн	219,616.78	(794,793.43)	-1,014,410.21
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,209,140.33	519,498.54	-689,641.79

Эх сурвалж: Орхон сумын 2022 оны нэгтгэсэн тайлангаас

Засгийн газрын хувь оролцоо өмнөх оны үлдэгдлээс 43.2 хувиар буурсан нь дээр дурдсан боловсрол, соёлын төсвийг хариуцах эрх шилжсэнтэй холбоотой буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны VI/04 тоот тогтоолоор сумын 2022 оны төсвийг 793,956.6 мянган төгрөгөөр баталж сумын татварын болон татварын бус орлогыг 435,062.8 мянган төгрөгөөр, аймгаас олгох санхүүжилт 543,150.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,000.0 мянган төгрөг, ОНХС-гаас олгох шилжүүлэг 259,956.5 мянган төгрөг, ОНХС-гийн өмнөх оны үлдэгдлээс 98,000.0, өмнөх оны малын хөлийн татварын орлогоос 103,000.0, 2022 оны малын хөлийн татвараас 140,000.0, байгаль хамгаалах сангийн өмнөх оны үлдэгдлээс 15,000.0, нөхөн сэргээх арга хэмжээний орлогоос 25,000.0, сум хөгжүүлэх сангийн өмнөх оны үлдэгдлээс 80,000.0, зээлийн эргэн төлөлтөөс 60,000.0, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн өмнөх оны үлдэгдлээс 5,000.0, зээлийн эргэн төлөлтөөс 8,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 30-ны 09/01 тоот тогтоолоор сумын 2022 оны төсвийг тодотгон 836,160.3 мянган төгрөгөөр баталж сумын татварын болон татварын бус орлогыг 450,744.9 мянган төгрөгөөр, аймгаас олгох санхүүжилт 479,915.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,000.0 мянган төгрөг, ОНХС-гаас олгох шилжүүлэг 259,956.5 мянган төгрөг, ОНХС-гийн өмнөх оны үлдэгдлээс 98,000.0, өмнөх оны малын хөлийн татварын орлогоос 103,000.0, 2022 оны малын хөлийн татвараас 140,000.0, байгаль хамгаалах сангийн өмнөх оны үлдэгдлээс 15,000.0, нөхөн сэргээх арга хэмжээний орлогоос 30,000.0, сум хөгжүүлэх сангийн өмнөх оны үлдэгдлээс 80,000.0, зээлийн эргэн төлөлтөөс 60,000.0, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн өмнөх оны үлдэгдлээс 5,000.0, зээлийн эргэн төлөлтөөс 8,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 980,970.8 мянган төгрөг, ОНХС-гаас 980,970.8 мянган төгрөг, үйл ажиллагаанаас 79,406.3 төгрөг, СХС-аас 120,625.3 мянган төгрөгийн зээл төлөгдөж, орлого 23,579.1 мянган төгрөгөөр дутуу биелсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,195,705.1 мянган төгрөг буюу 73.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 420,605.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлө-гөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	78,613.40	74,295.10	4,318.30	94.50691612
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	747,967.20	657,197.00	90,770.20	87.86441438
3	Орон нутгийн зорилтот Хөрөнгө оруулалт	587,150.00	269,009.90	318,140.10	45.81621391
4	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	16,850.00	14,247.70	2,602.30	84.55608309
5	Соёл урлаг	21,520.20	21,403.20	117.00	99.45632476
6	Сургуулийн өмнөх боловсрол	40,029.30	39,742.60	286.70	99.28377464
7	Ерөнхий боловсрол	123,320.50	119,809.70	3,510.80	97.15310917
	Нийт	1,616,310.90	1,195,705.20	420,605.70	73.977426

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр 1,050.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл авч "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна. /ЗДТГ/
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар заалтыг зөрчин 420.0 мянган төгрөгийн дүрэмт хувцас авсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. /ЗДТГ/
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5 зөрчин бэлэг дурсгалын зүйлд 3,960.7 мянган төгрөгийг зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангаагүй байна. /ЗДТГ/
- Шатахууны зардлыг шууд зардалд бичсэн нь УСНББОУС-12, НББ-ийн тухай хуулийн 20.2.3, 20.2.4 дэх заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. /ЗДТГ/
- Анхан шатны баримтгүй 1,013.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.4 20.2.4, дахь заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. /ЗДТГ/
- Шатахууны зардлыг тооцож олгоходоо автомашины зарцуулах шатахууны норм нормтивыг баримтлаагүй нийт 632.1 мянган төгрөгийг илүү тооцон олгож Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй. /ЗДТГ/
- Багийн иргэдийн нийтийн хурал даргалагч нарын урамшуулалд 2,100.0 мянган төгрөгийг холбогдох анхан шатны баримтгүй хавтгайруулан олгосон нь олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 -д заасан заалт, санхүүгийн тайлангийн аудит нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй. /ИТХ/
- Татварын ерөнхий хуулийн 28.5. "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаагүй, худалдан авалтын нийт 4,732.5 мянган төгрөгийн ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулаагүй. /ИТХ/
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлаас анхан шатны баримтгүй нийт 974.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 -д заасан заалт, санхүүгийн тайлангийн аудит нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй. /ИТХ/
- Сумын зам даваа засварын ажлын төсөвт өртөгт тусгагдсан захиалагчийн хяналтыг хийж гүйцэтгэсэн ажлын баримтгүй, ажил гүйцэтгэсэн аж ахуй нэгж байгууллагад захиалагчийн хяналтын зардал 404.5 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 290 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3.13, 3.19, 4.1-д заасан заалт, Барилгын тухай хуулийн 38.1.4, 38.1.8, Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 290 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3.13, 3.19, 4.1-д заасан заалтыг тус тус зөрчсөн байна. /ОНХС/
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь заалтыг зөрчин 40,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй зөөврийн орон сууц, 36,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худаг цахимжуулах, 45,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй зам даваа засах зэрэг төсөл арга хэмжээнүүдийг тус бүр 2-3 багц болгон хувааж шууд гэрээ байгуулсан. /ОНХС/

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 223,821.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сайхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ний өдрийн 01/67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,616,310.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 24,244.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сайхан сумын ТТЗ нь шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 01/836 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	39,400.0	2	39,400.0	100
Албан шаардлага	2	84,000.0	2	84,000.0	100
Зөвлөмж	2	0	2	0	
Нийт дүн	6	120,700.0	6	120,700.0	100

/мянган төгрөгөөр/

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 34,949.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 22,949.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 12,000.0 зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 96,288.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 4,912.2 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 85,593.0 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн байна.

5.1.Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт

Малын хөлийн татвар 22,949.1 мянган төгрөгийг дутуу ногдуулж, төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт хүргүүллээ.

5.2.Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

Малчид, төрийн албан хаагчдыг малжуулах төсөл, хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдад олгосон нийт 12,000.0 төгрөгийн малын авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

Илрүүлэлт:

Орон нутгийн орлого нийт дүнгээрээ биелсэн ч нэр төрлөөрөө хувь хүний орлогын албан татварын орлого, хөрөнгийн албан татварын орлого, бусад татвар хураамжийн орлого тасарсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д заасан заалттай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид орлогын төлөвлөгөөний төлөвлөлт түүний биелэлтэд дүн шинжилгээ хийж орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр биелүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	3	34.9	1	22.9	1	12.0	2					
Дүн	3	34.9	1	22.9	1	12.0	2				-	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
										-
										-
Дүн										-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
										-
										-
Нийт дүн										-